



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А177.

Сангиндалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7 дахь заалт, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Бэлчээр хамгаалах өдөр 185 дугаар тогтоол, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд бэлчээрийн хортон мэргэчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Энхдэлгэр (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: И.Дүрзээ (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүд:

Д.Цогбадрах (1-р багийн Засаг дарга)

Н.Гансүх (2-р багийн Засаг дарга)

Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)

Ж.Өлзийжаргал (6-р багийн Засаг дарга)

Ж.Түвшинбаатар (7-р багийн Засаг дарга)

Г.Энхтайван (Засаг даргын Тамгын газрын ажилтан)

2. Тухайн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөрт багтаан малчид, малчдын бүлгийг дайчлан чанартай, үр бүтээлтэй зохион байгуулсугай

3. Малчдын бүлгийг удирдлага арга зүйгээр хангаж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааврын дагуу ажиллуулж, гэрээ байгуулахыг багийн Засаг дарга нар, ажлын хэсэгт бэлчээрийн хортон мэргэчидтэй тэмцэх ажилд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Батбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнойтоой микробиологийн аргаар тэмцэх ажлын тайланг нэгтгэн сумын Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Г.Энхдэлгэр), нарийн бичгийн дарга (И.Дүрзээ) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН

ОРЛОГЧ

О.БАЗАРРАГЧАА

482302153